



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай АЗЗА ХК-ны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/03/-НА-СТА-ТӨҮГ

Цахим
www.audit.mn

Алтай хот
2022 он

хуудас:

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим

хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим

хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Аудитор Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
Байгууллагын үйл ажилагаа	8
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
3.10 өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт	11
4.2 .2 Төлбөрийн акт	11
4.2.3 Албан шаардлага	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 03. 15 № 168

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-Алтай авто зам, засвар арчлалт ХК-ны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай Говь-Алтай авто зам, засвар арчлалт ХК-ны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020450

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлтийн нэр	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. ХӨРӨНГӨ		
1.1. Эргэлтийн хөрөнгө		
1.1.1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	224,665,375.57	244,089,730.07
1.1.2. Дансны авлага	3,065,875.00	3,065,875.00
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	847,641.63	337,656.27
1.1.4. Бусад авлага	815,337.00	815,337.00
1.1.5. Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6. Бара материал	101,460,021.58	93,427,481.86
1.1.7. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо		
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	330,854,250.79	341,736,080.20
1.2. Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1 Үндсэн хөрөнгө	501,108,567.21	471,178,816.96
1.2.2 Биет бус хөрөнгө	351,400,000.00	351,160,000.00
1.2.3 Биологийн хөрөнгө		
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	852,508,567.21	822,338,816.96
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,183,362,817.99	1,164,074,897.16
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
2.1.1 Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.3 Татварын өр	0.00	288,415.00
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр	718,400.00	360,218.18
2.1.1.11 Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөд хам		
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	718,400.00	648,633.18
2.1.2 Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1 Урт хугацаат зээл	283,600,889.00	283,600,889.00
2.1.2.5 Зээл		
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	283,600,889.00	283,600,889.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	284,319,289.00	284,249,522.18
2.3 Эздийн өмч	101,167,000.00	101,167,000.00
2.3.1 Төрийн	101,167,000.00	101,167,000.00
2.3.5 Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,307,277.13	16,307,277.13
2.3.7 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	758,570,781.33	758,570,781.33
2.3.9 Хуримтлагдсан ашиг	22,998,470.53	3,780,316.52
2.3.10		
2.3.11 Эздийн өмчийн дүн	899,043,528.99	879,825,374.98
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,183,362,817.99	1,164,074,897.16

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	1,002,470,244.01	711,479,406.09
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	813,256,362.84	544,459,814.20
3. Нийт ашиг (алдагдал)	189,213,881.17	167,019,591.89
4. Түрээсийн орлого		
5. Хүүний орлого	5,947,414.52	
6. Ногдол ашгийн орлого		
7. Эрхийн шимтгэлийн орлого		
8. Бусад орлого		
9. Борлуулалт, маркетингийн зардал		
10. Ерөнхий ба удирдлагын зардал	168,860,283.65	170,644,127.86
11. Санхүүгийн зардал		
12. Бусад зардал	13,008,530.00	14,402,618.01
13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15. Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16. Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17. Бусад ашиг (алдагдал)		
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	13,008,530.00	(18,027,153.98)
19. Орлогын татварын зардал	1,382,100.29	
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	11,910,381.75	(18,027,153.98)
21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагд)		
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	11,910,381.75	(18,027,153.98)
23. Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн		
25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	101,167,000.00	16,307,277.13	758,570,781.33	11,088,088.78	887,133,147.24
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				11,910,381.75	11,910,381.75
9	2021 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	101,167,000.00	16,307,277.13	758,570,781.33	22,998,470.53	899,043,528.99
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-18,027,153.98	-18,027,153.98
15	Зарласан ногдол ашиг				1,191,000.03	1,191,000.03
17	2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	101,167,000.00	16,307,277.13	758,570,781.33	3,780,316.52	879,825,374.98

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,102,838,522.00	805,338,516.00
1.1 Мөнгөн орлогын дүн	1,102,838,522.00	805,338,516.00
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,087,217,911.00	782,627,346.00
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	15,620,611.00	22,711,170.00
1.2 Мөнгөн зарлагын дүн	993,527,470.39	717,083,161.47
Ажиллагчдад төлсөн	222,199,107.00	216,039,137.55
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	80,854,743.70	74,603,614.95
Бараа материал худалдан авахад төлсөн	282,628,694.00	110,414,215.00
Ашиглалтын зардал төлсөн	4,883,738.35	4,305,648.99
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	199,361,790.00	174,252,615.00
Хүүгийн төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	97,495,470.29	62,179,651.77
Даатгалын төлбөрт төлсөн	947,070.00	450,000.00
Бусад мөнгөн зарлага	105,156,857.05	74,838,278.21
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	109,311,051.61	88,255,354.53
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	5,947,414.52	
Мөнгөн орлогын дүн	5,947,414.52	
Хүлээн авсан хүүгийн орлого	5,947,414.52	
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн	67,830,000.00	67,640,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	67,830,000.00	67,640,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(61,882,585.48)	(67,640,000.00)
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(600,000.00)	(1,191,000.03)
Мөнгөн орлогын дүн		
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Мөнгөн зарлагын дүн	(600,000.00)	(1,191,000.03)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг	600,000.00	1,191,000.03
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(600,000.00)	(1,191,000.03)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	46,828,466.13	19,424,354.50
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	177,836,909.44	224,665,375.57
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	224,665,375.57	244,089,730.07

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай АЗЗА ХК-ны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн

Говь-Алтай АЗЗА ХК-ны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 27 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай АЗЗА ХК нь Хайрган болон хатуу хучилттай авто зам засварлах, зам замын байгууламжуудыг барих гэж үндсэн үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай АЗЗА ХК-ны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 995.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 19.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 15.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 729.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 14.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11.6 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажилагаа

Говь-Алтай АЗЗА ХК-ны зорилго нь улсын чанартай замаар зорчигчдыг ая духтай осол аваргүй нэвтрэн өнгөрүүлэн, үйл ажиллагааг өргөжүүлэн, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж шинэлэг материаллаг баазыг нэвтрүүлэн ажиллахад оршино.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд зам засвар арчлалт статустай байна. Өмчийн 100 хувийг төрийн өмч эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Говь-Алтай АЗЗА ХК нь Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 36 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах гэсэн заалттай нийцэж байна.

Говь-Алтай АЗЗА ХК-ны удирдлага болон ТУЗ-ыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас томилдог бөгөөд энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлтэй нийцсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгож гэж заасан байна. Дээрх асуудлын хүрээнд хөрөнгийн ашиглалт хамгаалалт сайжруулан ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог нэмэгдүүлээгүй, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоол

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	224,665.4	244,089.4	19.4
БХХО			
Авлага	4,728.8	4,218.8	(509.9)
Урьдчилгаа			
Бараа материал	101,460.0	93,427.5	(8,0 5)
Үндсэн хөрөнгө	501,108.6	471,178.8	(29,929.7)
Биет бус хөрөнгө	351,400.0	351,160.0	(240.0)
Нийт хөрөнгийн дүн	1,183,362.80	1,164,074.90	(19,287.90)
Өр төлбөрийн дүн	284,319.2	284,249.5	(69.7)
Богино хугацаат өглөг	714.8	648.6	(69.7)
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч	899,043.5	879,825.4	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,183,362.8	1,164,074.9	(19,287.9)

Касс дахь болон банк дахь мөнгөний үлдэгдэлд 244.1 сая төгрөг байна.

Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд хугацаатай гаргасан үнэт цаас байхгүй болно.

Авлагын үлдэгдэлд авлага 4.2 сая төгрөг, бусад хувь иргэн байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 93.4 сая төгрөг болж 8.0 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд худалдан авсан болон үнэ төлбөргүй ирсэн бараа материал байхгүй болно.

Бараа материалын зардалд ашиглалтгүй 1.4 сая төгрөгийн бараа материалыг өмч хамгаалах комиссын шийдвэрээр устгаж нотлох баримтыг хавсаргасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,806.5 сая төгрөг болж өссөн нь Эвийн гүүрний буудлын барилгын засварын ажил хийгдсэн, шилжүүлэн авсан 42.1 сая төгрөгийн автобус, зам засварын машин тоног төхөөрөмж 43.3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэнтэй холбоотой.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй бөгөөд 351.1 сая төгрөг байна.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэлгүй бөгөөд тайланд онд бүртгэсэн хөрөнгө оруулалт байхгүй болно.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 0.6 сая төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөр дансанд 2008 онд 21 аймгийн АЗЗА ХК-уудад Күветийн сангаас тоног төхөөрөмж нийлүүлж өглөгөөр бүртгэсэнтэй холбоотойгоор үүссэн 283.6 сая төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь шалтгаалсан нь график төлөвлөгөө байхгүй учраас төлөгдөөгүй салбарын хэмжээнд байгаа зөрчил тул яамнаас нэгдсэн шийдвэрээр хангах чиглэл өгсөн байгаа байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2016 онд батлагдсан мөрдөгдөж байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 268.0 сая төгрөгөөр зардал буурсан хэдий ч алдагдалтай ажилласан байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу гүйцэтгэх захирал байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Говь-Алтай АЗЗА ХК-ны 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 626 дугаар тушаалаар Говь-Алтай АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 1,024.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,005.8 сая төгрөгөөр, 18.9 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Мөн хөрөнгө оруулалтын зардалд 75.0 сая төгрөгийг баталж өгсөн байна.

Гүйцэтгэлээр 711.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 729.5 сая төгрөгийн зардал гарган 18.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 711.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 313.2 сая төгрөг буюу 30% хувиар тасарсан, тайланд онд улсын чанартай зам засварын ажлын санхүүжилтийг зорилтод түвшинд батлагдсан төлөвлөгөөнөөс буурсан байна. Энэ нь аймгийн орон нутгийн зам арчилгааны тендерт орсон боловч авч чадаагүйгээс голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,005.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 729.5 сая төгрөг буюу 276.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь орлого дутуу орсон нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 4 нэр төрлийн 67.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 18.0 сая төгрөг болсон нь элэгдлийн зардал, шатахуун бараа материалын зардал өссөнтэй холбоотойгоор нөлөөлж байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу

Шилэн дансны хууль, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансанд байршуулах 1,655.7 сая төгрөгийн 85 мэдээллийг бүрэн байршуулсан байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага нь өмнөх онд зөрчил илрээгүй болно.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичиг, авлага, өглөгийг барагдуулсан, орлогын төлөвлөгөөний биелэлтийг үзэх зүйтэй гэж үзлээ

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 332.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.9 сая төгрөгийн залруулга, 331.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар 0.9 сая төгрөгийн залруулга хийгдлээ.

4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт 0.9 сая төгрөгийг аудитын явцад залруулав.

4.2.3 Албан шаардлага

Тайлант онд орлогын төлөвлөгөө 313.2 сая төгрөгөөр тасарч, 18.0 сая төгрөгийн алдагдалтай нь: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 626 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасантай нийцэхгүй байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн 283.6 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т /Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага өглөө.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		3	332.2	1	0.9			2	331.2		
	Дүн	3	332.2	1	0.9			2	331.2		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Дүн										
	Нийт дүн	3	332.2	1	0.9			2	331.2		